



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО

Нийтийн эрх зүйн хуулийн этгээд

Очир төвийн 503 тоот, Олимпын гудамж, 1-р хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот,

Цахим хаяг: mto.mn, Цахим шуудан: info@mto.mn,

Утас: 976-77128822.

2026/05/11 № А/02/160

Танай _____ -ны № _____ -т

Г Тодруулга авах тухай Г

Монгол Улсын Их Хурлаас Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 05-р сарын 04-ний өдөр баталсантай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангаж зорилгоор тус хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яам /хуучин нэрээр/-наас “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг 2023 оны 07-р сарын 07-ны өдөр Улаанбаатар хотноо үүсгэн байгуулсан.

Улмаар манай байгууллага Аялал жуулчлалын тухай хуулийн 6.4, 6.6, 10.1, 12.1, 13.2, 18.3-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд аялал жуулчлалын байгууллага, жуулчны хөтөч-тайлбарлагчийн бүртгэлийг хуульд заасны дагуу явуулж байна. “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээд 2026 оны 06-р сарын 11-ний өдрийн байдлаар нийт 868 гишүүнтэй бөгөөд үүнээс 415 нь тур оператор, 200 нь жуулчны хөтөч-тайлбарлагч, 181 нь аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагаас 113 жуулчны бааз 68 зочид буудал, 26 нь аяллын агент, 35 нь нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгч болон төрийн буё байгууллагууд, 11 жуулчин тээврийн жолооч, 19 салбар холбоо бүртгэлтэй байна.

Монгол Улсын Их Хурлаас Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн өөрчлөн найруулсантай холбогдуулан тус хуулийн зарим зохицуулалтыг практикт нэг мөр ойлгож хэрэглэх, хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах 4 асуудлаар тайлбар, тодруулга өгөхийг хүсэж энэхүү албан бичгийг хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалт: “тухайн салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоодын олонхын төлөөлөл бүхий гишүүнчлэлтэй байх” гэх заалтын талаар дараах асуултад хариулж өгнө үү:

- “Мэргэжлийн холбоодын олонхын төлөөлөл” гэдгийг ямар шалгуур, аргачлалаар тодорхойлох вэ?
- Тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн холбоодын тоо, бүртгэлийн мэдээллийг ямар байгууллагаас гаргуулан авах боломжтой вэ?
- “Олонх” гэсэн ойлголтыг улсын бүртгэлд бүртгэлтэй нийт холбоодын 50-аас дээш хувь гэж үзэх үү, эсхүл бодит үйл ажиллагаа явуулж байгаа холбоодын тоонд үндэслэн тооцох уу?

Хоёр. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалт: “энэ хуулийн 5.3.1-д заасан гишүүдийн үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалт нь тухайн салбарын зах зээлийн 50-аас дээш хувийг эзэлдэг байх” гэх заалтын талаар дараах асуултад хариулж өгнө үү:

- Дээрх нөхцөлийг хангасан болохыг нотлох баримтыг ямар байгууллагаас гаргуулан авах вэ? (Татварын ерөнхий газар, Сангийн яам г.м байгууллагаас авах боломжтой эсэх?)
- Салбарын нийт зах зээлийн хэмжээ болон гишүүн байгууллагуудын үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалтын хэмжээг ямар статистик, санхүүгийн мэдээлэлд үндэслэн тодорхойлох вэ?
- Улсын бүртгэлийн байгууллагад ямар төрлийн нотлох баримт бүрдүүлэн хүргүүлэх шаардлагатай вэ?

Гурав. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг: “Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэхтэй холбогдсон журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална” гэх зохицуулалтын талаар:

- Тус зүйлд заасан Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх журмыг Засгийн газар хараахан батлаагүй байгаа нөхцөлд Мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах болон бүртгүүлэх хүсэлт гаргавал ямар журмаар шийдвэрлэх вэ?
- Журам батлагдах хүртэл хугацаанд хуулийн 5 дугаар зүйл болон бусад холбогдох зүйлд заасан шаардлага, баримт бичгийг бүрдүүлэн улсын бүртгэлд бүртгүүлэх боломжтой эсэх талаар тайлбар өгнө үү.

Дөрөв. Манай байгууллага нь өмнө дурдсанчлан Аялал жуулчлалын тухай хууль батлагдсантай холбоотойгоор яамнаас байгуулж “нийтийн эрх зүйн хуулийн этгээд” гэх статусаар улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд “нэгдсэн холбоо”-оор бүртгүүлэх тохиолдолд:

- Хуульд нийцүүлэн дахин шинээр байгуулагдах шаардлагатай юу?
- Эсхүл дүрэм, бүтэц, гишүүнчлэлийн бүрэлдэхүүндээ өөрчлөлт оруулан хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах замаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжтой юу?

Дээрх асуудлуудаар хууль тогтоомжийг нэг мөр хэрэглэхэд шаардлагатай албан ёсны тайлбар, чиглэл өгч хамтран ажиллана уу.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  М. НАРАНГЭРЭЛ



Санал

“Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх журам”-ын төсөлтэй танилцаад саналаа бичиж хүргүүлж байна. Үүнд:

1. Эхний асуудал нь Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.2-д заасан гишүүдийн үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалт нь тухайн салбарын зах зээлийн 50-аас дээш хувийг эзэлдэг байх шаардлага байна. Холбоодын шугамаар асуулга тавихад төрийн байгууллага энэ талаар нотолгоо, тодорхойлолт өгч чадаагүй. Зарчмын хувьд улсын бүртгэлийн байгууллага Өрсөлдөөний тухай хуулийн дагуу зүй ёсны монополь болон давамгайл байдалтай аж ахуйн нэгжийн талаарх нотолгоог Монополийн эсрэг газраас авах шаардлага гарна.

2. Гишүүдийн үйлдвэрлэл, борлуулалтын талаарх мэдээллийг санхүүгийн тайланг үндэслэн Татварын байгууллагаас гаргуулах уу эсвэл гишүүд тайлангаа өгөх үү гэсэн асуулт тавигдана.

3. МНХ-ны зөвхөн нэг гишүүн-холбооны үйлдвэрлэл, борлуулалт нь салбарын зах зээлийн 50-аас дээш хувийг эзэлдэг гэдгийг нотолсон бол шаардлага хангасан гэж үзэх боломжтой эсэх гэсэн асуулт гарч ирнэ.

4. Хуулийн 5.4-д тухайн салбарын мэргэжлийн холбоо дангаар хуульд заасан нөхцөл, шаардлагад нийцүүлэн бүртгүүлж, мэргэжлийн нэгдсэн холбооны чиг үүргийг хэрэгжүүлж болно гэж заасан. Үйлдвэрлэл, борлуулалт нь салбарын зах зээлийн 50-аас дээш хувийг эзэлдэг нэг мэргэжлийн холбоо дангаар бүртгүүлэхэд тавигдах шаардлагыг тусгаж өгөх. Ингэхгүй бол удаан жил, тогтвортой ажилласан холбоог өөрчлөн байгуулах шаардлага гараад байна.

5. Холбоо гишүүнчлэлгүй боловч дэргэдээ ажил, үйлчилгээг нь авдаг аж ахуйн нэгжүүд санаа бодлоо илэрхийлэх зорилготой Зөвлөл байгуулан, дүрэм гаргаад ажиллуулж байна. Холбоо гишүүнчлэлтэй байх үед гишүүд нь өөртөй ашигтай шийдвэр гаргуулах гээд байдаг дутагдал бий. Мөн аймаг, орон нутаг холбоонд хүсэлт гаргах үед нь гишүүнээр авч, дараа нь орон нутгийн салбар болгоод санхүүжилт өгч ажиллуулж байна. Эндээс харахад гишүүнчлэлгүй боловч гишүүн байгууллагатай мэт ажиллаж байна.

6. Олон улсын байгууллагын гишүүн болох Монгол Улс дахь холбоог дангаар нь бүртгэх зохицуулалтыг тусгаж өгөх.

7. Мэргэжлийн нэгдсэн холбооны нэрийн асуудал, түүний зохицуулалтыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан бусад хуулийн этгээдийн нэр, хөтлөх сангаас тусдаа авч үзсэн байна.

- I. Улсын бүртгэлийн байгууллага нь Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-д зааснаар зөвхөн “МНХ”-ны нэрийн санг “тусгайлан” хөтөлнө.
- II. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Мэргэжлийн нэгдсэн холбооны нэр”-ийг онцолж, тусдаа зүйл, заалт оруулсан байна. Тухайлбал, “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д хамаарах салбарын байх, салбарын өөрийн онцлогийг илэрхийлсэн оноосон нэртэй байх, дэлгэрэнгүй болон товчилсон тэмдэглэгээтэй байх зэрэг.

- III. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-д зааснаар Нэгдсэн холбооны нэрийг МНХ-г үүсгэн байгуулах хурлаар хэлэлцэж, батлаад шийдвэрлэсэн байна.
- IV. Хуульд заасны дагуу МНХ-ны нэрийг хурлын тэмдэглэл, тогтоолдоо тусгаад оруулсан, холбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүд баталгаажуулах, илгээх хүсэлтдээ холбооны бүтэн болон товчилсон нэрээ оруулсан байх зохицуулалт хуулийн 6.2, 6.3-дэх заалтад байна.

“Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д хамаарах Хуурай замын тээврийн салбар дахь бүх төрлийн автотээвэр, төмөр замын салбарын холбоод нэгдэж “Хуурай замын тээврийн салбарын мэргэжлийн нэгдсэн холбоо”-г байгуулсан.

Засгийн газрын 2018 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журам”-д заасны дагуу 2024, 2025 онд “Хуурай замын тээврийн салбарын МНХ” гэсэн нэр авах хүсэлтийг удаа дараа цахимаар хүргүүлсэн боловч бүтээгүй. Шалтгаан нь хуулийн дагуу бүртгэл нь Дээд шүүхэд хамаарах асуудал байна, хуульд зааснаар оноосон нэрээ үүсгэн байгуулах хурлаараа батална, МНХ гэсэн нэр олгохгүй байгаа, нэрийн санг тусдаа хөтөлнө зэрэг.

Ингээд Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3-д заасны дагуу МНХ-г үүсгэн байгуулах хурлаараа оноосон нэрний асуудлаа хэлэлцэн баталж, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн Дээд шүүхэд 2025 оны 01 дүгээр сарын 10-д хүргүүлж, 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.

Саналаа бичсэн:

ЧД-ийн 6 дугаар хорооны харьяат Д.Баярхүү, харилцах утас: 7011-8638

Иргэн Д.Ганболд

Санал

Сайн байна уу. МНХ-ны эрх зүйн байдлын тухай хууль гарч УДШ-ээс бүртгэх журам гарсантай холбогдуулан 2025 оны 5 сард материал бүрдүүлэн бүртгүүлэхээр УДШ-д материалаа өгсөн боловч 1 жил хүлээгээд сая 2026,05 сард өгсөн материалаа буцааж авсан юм.

Надтай адил ийм маягаар бүртгүүлэх материал өгөөд хүлээгдсэн хүмүүс байгаа л болов уу гэж бодож байна.

Тэгэхээр сая 2026 онд хуулинд өөрчлөлт орж УБГ-т МНХ-г бүртгэх болсонтой холбогдуулан ЗГ-ын тогтоолоор батлагдах Журмын төсөлтэй танилцлаа, үндсэндээ УДШ-ээс өмнө баталж байсан журамтай төстэй учир дэмжиж байна.

Харин МНХ-гоо өнгөрсөн онд байгуулаад материалаа бүрдүүлж өгөөд 1 жил хүлээсэн бид хуучин материалаа нэгтгэж боогоод, бүртгүүлэх хүсэлтээ шинээр бичиж өгч болох талаар талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч өгнө үү.

МНХ-ны хуульд өөрчлөлт орж одоо л танай байгууллага бүртгэлийг хариуцаж эхэлсэнд талархаж байна.

Баярлалаа.

Холбоо барих утас.

99114436

80110279